

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2014 оны 9 дугаар сарын 4 өдөр

Дугаар 1208/2014

Улаанбаатар-15171
 Утас: 323022, 328097
 Факс: 976-11-320338

Объектын нэр:	Чоно харайхын гол дээр баригдах 37.68 у.м ган төмөр бетон гүүрийн зураг төсөл ШИФР: 10/14			
Объектын байршил:	Ховд аймгийн Дөргөн сум			
Хүчин чадал:	37.68 м-ийн урттай, "Т" хэлбэрийн ган дам нуруу бүхий төмөр хавтангаар нэгтгэсэн нэгдмэл алгаслал байгууламж			
Захиалагч:	Ховд аймгийн Засаг даргын тамгын газар			
Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар			
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр,	"ГБЭТ" ХХК			
Регистрийн дугаар:	РД: 2089491			
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2016.02.15			
Ажилбарын төрөл:	1.3.3			
Зураг төсөл боловсруулах үндэслэл:				
Үндсэн бичиг баримт	Дугаар	Огноо	Тайлбар	
Газар эзэмших эрхийн захирамж	A/29	2014.06.27	Ховд аймгийн Дөргөн сумын Засаг дарга	
Зураг төсөл боловсруулах даалгавар	№ 14/01	2014.06.27	Ховд аймгийн Засаг даргын баталсан зургийн даалгавар	
Зураг төсөл боловсруулах гэрээ	№ 2014/03	2014.06.24	Ховд аймгийн Засаг дарга, "ГБЭТ" ХХК-ийн хооронд байгуулсан гэрээ	
Техникийн нөхцлүүд:				
Гадна инженерийн хангамжийн техникийн нөхцлүүд	Олгосон байгууллага	Олгосон дугаар	Олгосон огноо	Хүчинтэй хугацаа
-	-	-	-	-
Зөвшөөрөлцсөн байгууллагууд:				
-				
Зураг төслийн бүрэлдэхүүн:				
Зургийн бүрдэл:	Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр		Шалгасан экспертний нэр	
Гүүрийн ажлын зураг	"ГБЭТ" ХХК		Д.Хадбаатар	
Ажлын зургийн тайлбар бичиг	"ГБЭТ" ХХК		Д.Хадбаатар	

Техникийн шаардлага	"ГБЭТ" ХХК	Д.Хадбаатар
Төсөв	"ГБЭТ" ХХК	Б.Минжбадам
Инженер геологийн судалгаа	"Таван үндэс" ХХК /Архив № 1726/	Дүгнэлт баталгаажсан
Ерөнхий дүгнэлт: <i>/Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлээс/</i>		
Барилга байгууламжийн техникийн ерөнхий өгөгдлийн болон техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт;	Барилга байгууламжийн хүчин чадал: Ховд аймгийн Дөргөн сумын Аргалант багийн нутаг дэвсгэрт "Дөргөний усан цахилгаан станц"-аас 12 км-т хуучин модон гүүрнээс баруун тийш 30 м зайд Чоно харайхын гол дээр ган төмөр бетон гүүр барих зориулалтаар Ховд аймгийн Дөргөн сумын Засаг даргын захирамжаар олгогдсон 1.2 га газарт 37.68 урт.метр ган төмөр бетон гүүрийн зураг төслийг аймгийн Засаг даргын баталсан зургийн даалгавар баталсан зургийн даалгаварыг үндэслэн боловсруулсан байна. Төлөвлөлт: Уг гүүрийг 37.68 м-ийн урттай, "Т" хэлбэрийн ган дам нуруу бүхий төмөр хавтангаар нэгтгэсэн нэгдмэл алгаслал байгууламж байхаар төлөвлөсөн байна. Барилгын инженер-хайгуулын "Таван үндэс" ХХК-д боловсруулсан /Архив № 1726 тоот/ инженер геологийн судалгааны дүгнэлтээр гүүрийн шинэчлэлтийн хэсэг нь газар хөдлөлтийн 8 баллын бүсэд хамрагдаж байна.	
Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаархи тодорхой санал, дүгнэлт;	Гүүрийн хучлагын хийц нь: 1.5 м-ийн өндөртэй ган дам нуруу нь +0.2 м өргөнтэй төмөр бетон хавтан бөгөөд гүүрийн төмөр бетон бүтээцэд хэрэглэгдэх бетон нь "В" ангиллын, хэрэглэгдэх арматур нь MNS JIS G: 3112-2002 стандартын, төмөр бетон бүтээцэд хэрэглэгдэх ган нь "SD болон SR" ангиллын марктай байхаар тооцож төлөвлөсөн байна.	
Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан гаргасан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаархи дүгнэлт.	Чоно харайхын гол дээрх одоо байгаа эвдэрч ашиглалтгүй болсон модон гүүрийг ган төмөр бетон гүүр болгон шинэчилснээр Ховд аймгийн Дөргөн сумын Аргалант багийн ард иргэд, орон нутгийн хөгжилд бодитой хөрөнгө оруулалт болох юм.	

Төсөв	Эксперт нь: 37.68 урт.метр ган төмөр бетон гүүрийн төсөвт өртгийг 1 479 984 429 /нэг тэрбум дөрвөн зуун далан есөн сая есөн зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун хорин есөн/ төгрөгөөр хянасан байна.

“Барилгын тухай” хуулийн 13.4-т заасны дагуу “Зураг төсөл зохиогчийн гаргасан алдааг зураг төслийн байгууллага, зохиогч хариуцах бөгөөд магадлал хийсэн этгээд нь зураг төслийн техникийн шийдлийн талаар гаргасан дүгнэлтийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.”

Ховд аймгийн Дөргөн сумын Аргалант багийн нутаг дэвсгэрт Чоно харайхын гол дээр баригдах 37.68 урт.метр ган төмөр бетон гүүрийн зураг төсөл, төсөвт “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм”, “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНБД 81-94-12/, “Төсөв зохиох дүрэм” /БНБД 81-95-12/, Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын 2014.08.20-ний өдрийн 7/2209 тоот албан бичгийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Ерөнхий дүгнэлт нь экспертүүдийн 5 хуудас хавсралт дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ

МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН



Б.БАЯРСАЙХАН

Б.БАТ-ЭРДЭНЭ

Д.БАТБААТАР